



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

Нярайн тандалт шинжилгээний
хөтөлбөр (2014-2020) батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016 оны хөтөлбөрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөр (2014-2020)”-ийг хавсралтаар баталсугай.

2. Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д үүрэг болгосугай.

3. Нярайн тандалт шинжилгээнд шаардлагатай нөөцийг жил бүрийн төсөвт тусгах ба, гадаад дотоодын бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх, холбогдох мэргэжилтэн бэлтгэх, сургах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Эрүүл мэндийн яамны Санхүү эдийн засгийн хэлтэс /Д.Төмөрбаатар/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/-д даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газар /дарга С.Төгсдэлгэр/, жил бүр явцын үнэлгээ хийж, Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулж байхыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/- д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

081605

НЯРАЙН ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (2014-2020 ОН)

1. Үндэслэл, өнөөгийн байдал

Нярайн тандалт шинжилгээ буюу скрининг нь илэрхий шинж тэмдэггүй төрөлхийн ба удамшлын өвчнийг энгийн, хурдан, аюулгүй аргаар баталгаатай технологи ашиглан, нярайн эрт үед илрүүлэн оношилж, эмчилгээнд хамруулах зорилготой. Ингэснээр нярайн өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсэхээс эрт сэргийлэх боломж олгоно. Удамшлын ба төрөлхийн эмгэгээс үүдэлтэй өвчлөлийг багасгах нь эрүүл мэндийн төдийгүй нийгмийн халамж, тусгай боловсролд зарцуулах зардлыг бууруулах нийгэм эдийн засгийн ач холбогдолтой.

Түнхний үений төрөлхийн мултрал ба дутуу хөгжил нь (дисплази) хүүхдийн яс, булчингийн тогтолцооны эмгэгээс хамгийн түгээмэл тохиолддог эмгэг юм. Түнхний үений дисплазийг эрт оношилж, эмчлээгүй тохиолдолд үений үрэвсэл (артроз), мултрал үүсч насан туршид нь хөгжлийн бэрхшээлтэй болгон, улмаар гэр бүл, нийгэмд сөрөг үр дагаварыг дагуулдаг. Иймд Швейцарь, Австри, Герман зэрэг өндөр хөгжилтэй оронд нярайн түнхний дисплазийн хэт-авиан тандалт шинжилгээг 30 гаруй жилийн өмнөөс нэвтрүүлжээ. Монгол улсад 2008 оноос Монгол-Швейцарийн хамтарсан “Нярайн түнхний үений дисплазийн хэт-авиан скрининг оношилгоо, мултралаас сэргийлэх эмчилгээ” төслийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-д туршин хэрэгжүүлж үр дүнтэй нь нотлогдсон. Төслийн хүрээнд 2010-2011 онд нийт 8'544 нярайг төрсний дараах 1-2 хоногт түнхний үений хэт-авиан шинжилгээнд хамруулснаас 14.1%-д физиологийн дутуу хөгжил (II а хэлбэр), 1.3%-д мэс заслын бус эмчилгээ шаардсан хэлбэр (IIc, D, III ба IV хэлбэр) оношлогдож эмчилгээамжилттай хийгээд байна. Төрсөн хүүхэд бүрийн түнхний үений хэт-авиан зургийг Швейцарийн зөвлөхүүдэд онлайнаар илгээж, оношийг баталгаажуулсан ба оношилгоо, эмчилгээнд зөвлөгөө өгч хамтран ажилласнаар хяналтын тогтолцоог амжилттай бүрдүүлсэн. 2014 оноос ЭХЭМҮТ-ийн өөрийн лаборатори, мэргэжилтнүүдийн хүчээр дагнан хийж эхлээд байна.

Нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн тандалт шинжилгээ нь дэлхийн олон улсад хамгийн амжилттай хэрэгжиж байгаа хөтөлбөрийн нэг юм. Дэлхий дахинаа 1965 оноос нярайн скрининг шинжилгээг хийж эхэлсэн ба одоо дэлхийн 70 гаруй орны 475 гаруй лабораторид 40 гаруй нэр төрлийн эмгэгийг илрүүлэх шинжилгээ хийгддэг байна. Хэдийгээр тохиолдлын тоо харилцан адилгүй (700-100000 төрөлтөнд 1 тохиолдол) байх хэдий ч бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэг нь төрснөөс хойш 7-10 хоногт маш хүнд, амь тэнссэн, эргэшгүй өөрчлөлтийг үүсгэх тул эрт үед нь илрүүлэн, эмчлээгүй тохиолдолд нярайн эндэгдэлд хүргэх эрсдэл өндөр ба хөнгөн хэлбэрийн үед хөгжлийн бэрхшээл үүсгэдэг. Нярайн бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг эрт илрүүлж, эмчилснээр хүүхэд хэвийн, эрүүл хүүхдийн адил өсч торних боломжтой болно. Монгол улсад 2000 оноос бамбай булчирхайн төрөлхийн дутлын скрининг оношилгооны төслийг олон улсын цөмийн энергийн байгууллагын дэмжлэгээр туршиж эхэлсэн. Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхим, ЭХЭМҮТ-ийн хамтарсан

“Төрөлхийн гажгийг эрт илрүүлэх, нярайн эндэгдлийг бууруулахад пренатал оношилгоог нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд 2012 онд ЭХЭМҮТ, нийслэлийн 1, 2, 3-р амаржих газарт төрсөн 3000 гаруй нярайг бамбай булчирхайн төрөлхийн анхдагч дутал, ба адреногенитал хамшинжийн шинжилгээнд хамруулж, төрөлхийн анхдагч гипотиреозтой нэг нярайг илрүүлэн хяналтанд авч, эмчилсэн байна.

Сонсголын бэрхшээл нь нярайд хамгийн элбэг тохиолддог эмгэгийн нэг юм. Хүүхдийн сонсгол бууралтыг оройтож мэдсэнээр цаашдаа хэлгүй, дүлий байдалд хүргэдэг. Өнөө үед дүлий ба сонсголын бэрхшээлтэй 10 хүн тутмын нэг нь мэсзаслаар, үлдсэн 9 нь орчин үеийн сонсголын аппаратны тусламжтайгаар сонсголоо сайжруулж байгаа бөгөөд огт сонсголгүй хүнийг зөвхөн дунгийн суулгацаар сонсгол оруулж байна. Манай оронд нийт хүн амын 12.1%-д сонсголын эмгэг илэрч, одоогоор 240'000 гаруй хүн сонсголын өөрчлөлттэй байна. Түүнчлэн 1000 төрөлт тутамд 1.2-1.3 огт сонсголгүй хүүхэд төрж, тэр нь амьдралын хугацаанд 2 дахин өсдөг гэсэн мэдээлэл байна. Сонсголын тандалт шинжилгээ хийгдэхэд дээрх үзүүлэлт 3-4 болж нэмэгддэг. Нярайн сонсголын бууралт ихэвчлэн хожуу буюу 2-3 насанд оношлогддог. 2012 онд ЭХЭМҮТ-д нярайн сонсголын скринингийн судалгаанд нийт 2000 гаруй нярайг хамруулан 2 тохиолдлыг эрт илрүүлэн, оношилсон нь манайд нярайн дунд сонсголын эмгэг ховор бус тохиолдож буйг илэрхийлж байгаа бөгөөд нярайн сувилагчид энэхүү оношилгоог амаржих газарт стандарт аргаар гүйцэтгэх боломжтой болохыг харуулсан.

Дутуу нярайн ретинопатийг эрт илрүүлж, эмчлээгүйгээс сохрол үүснэ. Дэлхийн олон оронд хийсэн судалгаанаас үзэхэд 1500 граммаас доош жинтэй нярайн 19-47%, 1000-аас доош жинтэй нярайн 54-100%-д ретинопати үүсдэг байна. ДЭМБ-ын удирдамжийн дагуу жирэмсний тээлтийн 22 долоо хоногтойгоос дээш хугацааг төрөлт хэмээн тооцох болсноор дутуу төрөлтийн үед хэт бага жинтэй нярайд тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэх шаардлага урган гарч байна.

ДЭМБ-ын мэдээлснээр шинээр мэндэлсэн 10 хүүхэд дутмын нэг нь дутуу төрж байна. Анагаах ухаан хөгжихийн хирээр дутуу нярайн амьдрах чадвар нэмэгдэж байгаа ч амьдарсан хүүхдийн дунд тархины саажилт, нүдний торлогийн эмгэг буюу ретинопати зэрэг хүндрэл хугацаандаа төрсөн хүүхэдтэй харьцуулахад элбэг тохиолддог.

Үр шилжүүлэн суулгах ажилбар Монгол улсад хийгдэж байгаатай холбоотой дутуу төрөлтийн хувь нэмэгдэх хандлагатай болж байна. Иймд дутуу нярайн ретинопатиг эрт илрүүлэх, оношлогдсон тохиолдлыг цаг алдалгүй эмчлэхийн тулд 34 долоо хоногоос доош тээлтийн настай, 2000 граммаас бага жинтэй төрсөн бүх нярайг харааны тандалт шинжилгээ оношилгоонд хамруулах шаардлагатай. 2012 оноос ЭХЭМҮТ-д дутуу нярайн ретинопатийг эрт илрүүлэх, тандалт шинжилгээний ажлыг эхлүүлсэн. 2012 оны 09 дүгээр сарын 01-ээс олон улсын стандартын дагуу төрөх үеийн жин 2000 гр-аас бага, 34 долоо хоногоос доош тээлтийн настай дутуу нярайг скрининг оношилгоонд хамруулж 1 жилийн хугацаанд 36 өвчтөний 70 нүдэнд дутуу нярайн ретинопатийн эмчилгээ амжилттай хийгдсэн.

2. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь нярайн тандалт шинжилгээний иж бүрэн аргыг үе шаттайгаар эрүүл мэндийн тогтолцоонд бүрэн нэвтрүүлснээр нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах, хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэхэд оршино.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД

Зорилт 1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нярайн тандалт шинжилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Нийтлэг үйл ажиллагааны чиглэл

- 1.1 Эрүүл мэндийн яамны дэргэд нярайн скринингийн асуудлыг мэргэжил арга зүйгээр ханган, бодлого төлөвлөлтөд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг шинээр байгуулан, шийдвэр гаргагчид, олон талт хамтын ажиллагаанд оролцогсдод ухуулга нөлөөлөл хийх, нярайн тандалт шинжилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
- 1.2 ЭХЭМҮТ-ийн дэргэд тандалт шинжилгээний лавлагаа нэгжийг байгуулан нярайн тандалт шинжилгээний үйл ажиллагаа, хяналт, бүртгэлийн тогтвортой байдлыг бүрдүүлэх;
- 1.3 Нярайн тандалт шинжилгээний эрх зүйн ба ёс зүйн баримт бичгүүд, зайлшгүй шаардлагатай журам, зааврыг боловсруулан, баталгаажуулах;
- 1.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх төгсөлтийн өмнөх ба дараах сургалтын хөтөлбөрт нярайн тандалт шинжилгээний асуудлыг тусгаж, сургалтын материал боловсруулах;
- 1.5 Нярайн тандалт шинжилгээ, оношилгоо, хүндрэлээс сэргийлэх эмчилгээ, хяналтын тусламж үйлчилгээг амаржих газарт ажиллаж буй нярайн ба дүрс оношилгооны эмч, нярайн эргэлт хийдэг өрхийн эмч, сувилагч, лабораторийн тусламж үйлчилгээтэй нягт уялдуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ажил үүргийн чиглэлд тусгаж өгөх;
- 1.6 Нярайн тандалт шинжилгээ, оношилгоо, эмчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, хангамжийн бэлэн байдал, тусламж үйлчилгээний тогтвортой байдлыг хангахын тулд улсын төсөвт тодорхой үе шаттайгаар тусгах замаар төрөөс санхүүжүүлэх;

Өвөрмөц үйл ажиллагааны чиглэл

- 1.7 Нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн скрининг шинжилгээнд цусны дээж цуглуулах, хадгалах, шинжлэх, зөөвөрлөх, мэдээлэх талаар стандарт протокол, ёсзүйн зөвшөөрөл, эрхзүйн баримт бичгийг боловсруулан батлуулах;
- 1.8 ЭХЭМҮТ-ийн удамзүйн лабораторид бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн тандалт шинжилгээ, оношийн баталгаажилтын лавлагаа тусламж, үйлчилгээг бий болгох;

Хүлээгдэж буй үр дүн

1. Шинээр мэндэлж буй нярайг 4 төрлийн тандалт шинжилгээнд хамруулах (нярайн түнхний үений хэт авиан скрининг, бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн скрининг, нярайн сонсголын скрининг, дутуу нярайн ретинопатийн скрининг) хууль эрх зүйн орчин нөхцөл бүрдсэн байна.
2. Нярайн тандалт шинжилгээнд хамруулалт нь сайн дурын үндсэн дээр холбогдох хууль журмуудын хүрээнд зохион байгуулагдах ба гэр бүл хамт олны мэдлэг, хандлага сайжирсан байна.

Зорилт 2. Хүн амын дунд мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, гэр бүл, олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулан, нярайн тандалт шинжилгээний хамралтыг өргөжүүлэх;

Үйл ажиллагааны чиглэл

- 2.1 Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, жирэмсний хяналт, эхчүүдтэй ажилладаг эрүүл мэндийн ажилтнууд зөвлөгөө өгөх болон жирэмсний хяналтын явцад нярайг тандалт шинжилгээнд хамруулахын ач холбогдлыг гэр бүл, эцэг эхэд ухуулан ойлгуулах тогтолцоог бүрдүүлэх;
- 2.2 Нярайн асрамжлагчтай хийх зөвшилцлийн баримт бичиг (таниулсан зөвшөөрлийн хуудас) боловсруулж, хүүхдийн шинжилгээний хариуны нууцыг хадгалах баталгаа зэрэг асуудлыг тайлбарлан; сайн дурын шинжилгээ хийлгэх сэтгэл зүйн бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;
- 2.3 Гэр бүл, эцэг эх, олон нийтэд хандсан тандалт шинжилгээтэй холбоотой сургалт сурталчилгааны материал боловсруулж, хэвлүүлэн нийтийн хүртээл болгох;
- 2.4 Нярайн тандалт шинжилгээний асуудлаар холбогдох эрүүл мэндийн ажилтны зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах сургалтад хамруулах;
- 2.5 Мэдээллийн бүх хэрэгслүүдийг ашиглан онлайн хичээл, цахим мэдээллийг түгээх;

Хүлээгдэж буй үр дүн

1. Гэр бүл эцэг эх сайн дурын тандалт шинжилгээнд хамрагддаг болсон байна.
2. Олон нийтэд зориулсан сургалт сурталчилгаа тогтмолжиж сурталчилгааны аргачлалтай болно.
3. Эрүүл мэндийн ажилтнууд зөвлөгөө өгөх арга барилыг эзэмшинэ.

Зорилт 3. Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгооны үндэсний чадавхийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

Үйл ажиллагааны чиглэл

- 3.1 Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэгийн ба дутуу нярайн ретинопатийн тандалт шинжилгээ, оношилгоо, хүндрэлээс сэргийлэх болон эмчилгээний асуудлаар эмнэлзүйн удирдамж, стандартуудыг олон улсын стандарт, аргачлалын дагуу эмгэг тус бүрээр боловсруулан ашиглах;
- 3.2 Олон улсад хэрэглэгдэж буй гарын авлага, сурах бичгийг орчуулж хэвлүүлэх;
- 3.3 ЭХЭМҮТ ба амаржих газар, нэгдсэн эмнэлгүүдийг хэт авиан аппарат, сонсголын аппарат, шинжилгээний дээж цуглуулах иж бүрдлээр үе шаттайгаар хангах;
- 3.4 ЭХЭМҮТ-ийн удамзүйн лабораторийн чадавхийг бэхжүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор бүрэн хангах;
- 3.5 Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтнийг өндөр хөгжилтэй оронд сургах, дадлагажуулах, гадаадын мэргэжилтнүүдтэй хамтарсан төсөл хэрэгжүүлэн ажлын байрны сургалтыг зохион байгуулах;

- 3.6. Нярайн скрининг оношилгоо, эмчилгээний бүртгэлийн дэвтэр боловсруулж, хөтлөх.

Хүлээгдэж буй үр дүн

1. Нярайн скрининг шинжилгээний үндэсний чадавх сайжирч санхүүгийн эх үүсвэр бүрдсэн байна.
2. Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн тохиолдол бүрийг хүндрэлээс сэргийлэх эмчилгээнд хамруулан эмчлэх боломж бүрдсэн байна.

Зорилт 4. Үндэсний хэмжээнд нярайн түнхний үений дисплазийн хэт авиан скрининг оношилгоо, бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн лабораторийн оношилгоо, нярайн сонсголын эмгэгийн ба дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгоо, хүндрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээний бүртгэл мэдээлэл, тандалтын тогтолцоог бүрдүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл

- 4.1 Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн тандалт шинжилгээ, оношилгооны баталгаажилт, хяналт, бүртгэл мэдээлэлд онлайн хяналтын тогтолцоог нэвтрүүлж, үндэсний мэдээллийн сан үүсгэх;
- 4.2 Онлайн хяналтын тогтолцоо ашиглан үндэсний ба олон улсын мэргэжилтэн, судлаачдын багийн хамтын ажиллагааг бүрдүүлэх; Үүнд: Хүүхдийн эмч, нярайн эмч, дүрс оношилгоо, бусад мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааг тогтмолжуулах;
- 4.3 Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэгийн ба дутуу нярайн ретинопатийн үндэсний хэмжээний тархвар зүйн ба онолын судалгааг цахим мэдээллийн сан дээр үндэслэн гүйцэтгэх боломжийг хангах;
- 4.4 Нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн скрининг шинжилгээний цусны дээжийн хадгалалт, тээвэрлэлт, оношийн баталгаажилт, эргэн мэдээлэх үйл ажиллагааг стандартчилах;
- 4.5 Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн тандалт шинжилгээ, оношлогоо эмчилгээний талаар судалгаа шинжилгээний ажлыг тогтмол давтамжаар зохион байгуулах.

Хүлээгдэж буй үр дүн

1. Түнхний үений дутуу хөгжил, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгооны чадамж бүх түвшинд дээшилж, оношийн баталгаажилт, гадаад, дотоод чанарын хяналт тогтмолжсон байна.
2. Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн тандалтын тогтолцоо бүрдэж өвчний хяналт сайжирсан байна

3. Хөтөлбөрийн шинэлэг буюу дэвшилттэй тал

1. Орчин үеийн анагаах ухааны шаардлагад нийцсэн, нярайн тандалт шинжилгээ - скринингийн үр дүнтэй, хор нөлөөгүй, өвдөлтгүй, энгийн, аргыг үндэсний хэмжээнд эмнэлзүйн практикт нэвтрүүлэн шинээр төрж буй нярайг хамруулснаар нийгмийн эрүүл мэндийн чухал асуудлыг шийдвэрлэнэ.
2. Төрөлхийн болон бодисын солилцооны эмгэгүүдийг эрт оношлон эмчилгээнд хамруулснаар уг өвчний улмаас үүсэж болох эргэшгүй өөрчлөлт, хөгжлийн бэрхшээлээс сэргийлж, эрүүл мэндийн төдийгүй нийгмийн халамж, тусгай боловсролд зарцуулах зардлыг бууруулах, эдийн засгийн өндөр үр ашигтай.
3. Монгол улсын нярайн тусламж, үйлчилгээг хөгжингүй орны жишигт ойртуулах боломж бүрдэнэ.
4. Тандалт шинжилгээгээр өвчнийг эрт илрүүлэн эмчилгээнд эрт хамруулснаар хүүхдийн эндэгдлийг бууруулах болон хөгжлийн бэрхшээлтэй тахир дутуу болохоос сэргийлэх ба хүндрэлийн үеийн эмчилгээ, гэр бүлийн ба тусламж үйлчилгээний хөрөнгө зардлыг бодитойгоор бууруулна.

4. Хөтөлбөрийн хэрэгжилт, зохион байгуулалт

Нярайн тандалт шинжилгээг 2014-2020 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үе шаттайгаар нэвтрүүлэн, үндэсний хэмжээнд бүрэн хэрэгжүүлнэ.

2014- 2016 онд ЭХЭМҮТ, Нийслэлийн амаржих газруудад төрсөн нярайг тандалт шинжилгээнд үе шаттай хамруулна. Түнхний дисплазийн тандалтыг ЭХЭМҮТ, нийслэл, баруун 5 аймгийг хамруулна.

ЭХЭМҮТ нь тандалт шинжилгээний лавлагаа байгууллага бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйгээр хангах, сургалт сурталчилгааг явуулах, оролцогч байгууллагын хамтын ажиллагааг зохицуулах, явцыг тайлагнах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

5. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг 6 сар тутам гаргаж хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр хийж, 2016 онд дунд хугацааны үнэлгээ хийнэ.

Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2013 он	Хүрэх түвшин	
		2016 он	2020 он
Нярайн скрининг шинжилгээг зохион байгуулахтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүд	0	5	
1. Нярайн түнхний үений дисплази, мултралын хэт авиан скрининг оношилгоо			
Нярайн түнхний үений дисплази, мултралын хэт авиан скрининг оношилгоо, эмчилгээ нэвтрүүлсэн эмнэлгийн байгууллагын тоо	10 (ЭХЭМҮТ, 1,2,3-р Амаржих газар, 5 аймаг)	15	Үндэсний хэмжээнд
Тандалт шинжилгээнд хамрагдсан нярайн хувь	20%	30%	>80%
2. Нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн скрининг оношилгоо			
Бамбай булчирхайн төрөлхийн дутагдлыг тандалт шинжилгээг нэвтрүүлсэн эмнэлгийн байгууллагын тоо	0	ЭХЭМҮТ	УБ хотын хэмжээнд
Фенилкетонури өвчний тандалт шинжилгээг нэвтрүүлсэн байгууллагын тоо			
Бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн скрининг оношилгоонд хамрагдсан нярайн хувь	<0.1%	30%	>50%
3. Нярайн сонсголын скрининг оношилгоо			
Нярайн сонсголын скрининг оношилгоог нэвтрүүлсэн эмнэлгийн байгууллагын тоо	0	ЭХЭМҮТ 1,2,3 Амаржих газар	Үндэсний хэмжээнд
Сонсголын скрининг оношилгоонд хамрагдсан нярайн хувь	<1%	30%	>60%
4. Дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгоо			
Дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгоо нэвтрүүлсэн эмнэлгийн байгууллагын тоо	0	ЭХЭМҮТ	УБ
Дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгоонд хамрагдсан нярайн хувь	<1%	40%	>70%
Тандалт шинжилгээгээр оношлогдоод эмчилгээнд хамрагдсан нярайн тоо	Түнх	297/32000	
	Гипотиреодизм	2/3000	
	Сонсгол	2/2000	
	Ретинопати	42/50/450	
	Фенилкетонури	0	

"НЯРАЙН ТАНДАЛТ ОНОШИЛГОО" 2014-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд	Эх сурвалж	Хариуцах байгууллага	Хугацаа
Зорилт 1: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нярайн тандалт шинжилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.					
1.1	ЭХЭМҮТ-д нярайн скринингийн нэгж байгуулах	Нэгж байгуулагдсан байна	Нэгж томилсон тушаал	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014
1.2	Шийдвэр гаргагчдад зориулсан ухуулга, нөлөөллийн уулзалт зохион байгуулах;	Уулзалтуудын тоо Оролцогчдын тоо	Уулзалтын тайлан	ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	2014-2020
1.3	Эмч, эмнэлгийн ажилтны зөвлөлдөх, туршлага солилцох уулзалт зохион байгуулах	Уулзалтын тоо Оролцогчдын тоо	Уулзалтын тайлан	ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	2014-2020
1.4	Төрөх эмнэлгийн нярайн эмч, сувилагч, төрсний дараах нярайн эрт үеийн эргэлтийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн тогтоож, мөрдүүлэх	Төрсний дараах нярайн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн ажил үүргийн хуваарийг баталсан ЭМ сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	2014
1.5	Нярайн тандалт шинжилгээний асуудлыг Засгийн газарт танилцуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэх	ЗГ-ын тогтоолын төсөл	ЗГ-ын тогтоол	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014
Зорилт 2. Хүн амын дунд мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, гэр бүл, олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулан, нярайн тандалт шинжилгээний хамралтыг өргөжүүлэх;					
2.1	Эцэг эхтэй зөвшилцлийн баримт бичиг (зөвшөөрлийн хуудас), хүүхдийн шинжилгээний хариуны нууцыг хадгалах баталгааны талаар зөвлөгөө өгөх хөтөлбөр боловсруулах	Боловсуулсан хөтөлбөр	ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	ЭХЭМҮТ	2014

2.2	Гэр бүл, эцэг эх, олон нийтэд хандсан тандалт шинжилгээтэй холбоотой сургалт сурталчилгааны материал боловсруулж, хэвлүүлэн нийтийн хүртээл болгох	Боловсруулсан материалын тоо	ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	ЭХЭМҮТ, 1,2,3-р Амаржих газар	2014-2020
2.3	Нярайн тандалт шинжилгээний асуудлаар холбогдох эрүүл мэндийн ажилтны зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах сургалтад хамруулах	Сургалтанд хамрагдсан ажилтны хувь	ЭМЯ, ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	ЭХЭМҮТ, 1,2,3-р Амаржих газар	2014-2020
2.4	Мэдээллийн бүх хэрэгслүүдийг ашиглан он-лайн хичээл, электрон мессежүүдийг түгээх	Файлсбүүк, гар утсаар түгээсэн мессежийн тоо	ЭХЭМҮТ, НЭМҮТ	ЭХЭМҮТ	2014-2020
Зорилт 3. Нярайн түнхний үений дисплази, мултрал, бодисын солилцооны төрөлхийн эмгэг, нярайн сонсголын эмгэг, дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгооны үндэсний чадавхийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна.					
3.1	Улаанбаатар хотын 3 амаржих газар, 5 аймгийн төрөх эмнэлгийг шаардлагатай хэт авиан аппарат ба бусад тоног төхөөрөмжөөр хангах	Скрининг оношилгоонд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	3 амаржих газар, 5 аймагт өгсөн тоног төхөөрөмжийн тоо	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014-2020
3.2	ЭХЭМҮТ-д нярайн бодисын солилцооны төрөлхийн эмгэгүүдийг илрүүлэх тандэм масс спектрометрийн аппарат, дархлаа дааврын шинжилгээний аппарат бусад тоног төхөөрөмж, урвалж, сорьц цуглуулах материалаар хангах	Скрининг оношилгоонд шаардагдах тоног төхөөрөмж, урвалж, материалаар хангагдсан байна.	ЭХЭМҮТ-д суурилагдсан багаж тоног төхөөрөмжийн тоо	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014-2020
3.3	Нярайн скринингийн сурах бичиг, гарын авлагыг орчуулж хэвлүүлэх	Гарын авлага, ном хэвлэгдсэн байна.	Хэвлүүлсэн номын тоо	ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	2014

3.3	Эмч мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийг өндөр хөгжилтэй оронд сургах	Эмч мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер өндөр хөгжилтэй оронд сургагдсан байна	Сургагдсан хүний тоо	ЭМЯ	2014
3.4	Эмч, мэргэжилтэнд ажлын байран дээрх сургалтыг тогтмол зохион байгуулах Улаанбаатар хот ба 5 аймагт	Анхан шатны сертификат олгох сургалтыг гадаад мэргэжилтний тусламжаар зохион байгуулах ба цаашдын батжуулах сургалтыг жилд 2 удаа Монгол мэргэжилтнүүд зохион байгуулах	Сургалтын тайлан	ЭМЯ, ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	2014
Зорилт 4. Үндэсний хэмжээнд нярайн түнхний үений дисплазийн хэт авиан скрининг оношилгоо, бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн лабораторийн оношилгоо, нярайн сонсголын эмгэгийн ба дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгоо, хүндрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээний бүртгэл мэдээлэл, тандаптын тогтолцоог бүрдүүлнэ.					
4.1	Онлайн серверт холбож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Нийслэлийн 1, 2, 3-р амаржих газар, 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг онлайн хяналтын тогтолцоонд холбогдсон байна	Телемедицинний сүлжээгээр мэдээлэл дамжуулдаг эмнэлгийн тоо	ЭМЯ, ЭХЭМҮТ-ийн нярайн скринингийн нэгж	2014-2020
4.2	Хөтөлбөрт оролцох эмч, эмнэлгийн ажилтнуудыг Онлайн серверт ажиллах сургалтанд хамруулна.	Сургалт зохион байгуулсан байна.	-Зохион байгуулагдсан сургалтын тоо - Хамрагдсан хүний тоо	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014-2020

4.3	Нярайн скринингийн оношилгоо, эмчилгээ, хяналтыг бүртгэж мэдээлэх удирдамж боловсруулна.	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан удирдамж	Төрөх эмнэлгийн сар, улирал, жилийн тайлан	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014
4.5	Төрөх эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх жил бүр			ЭМЯ, ЭХЭМҮТ	2014-2020
4.6	Нярайн скрининг оношилгоо, эмчилгээ, эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийх	Судалгаа хийгдсэн байна	Судалгааны тайлан	ЭМЯ, ЭХЭМҮТ	2014-2020
4.7	Хөтөлбөрийн эцсийн үнэлгээг хийлгэх				

6. Хөтөлбөрийн өртөг зардлын товчоолсон тооцоо, түүний задаргаа

"Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эмч, эмнэлгийн ажиллагсдын цалин нэмэгдлийг тооцолгүйгээр 1,820,500,000 төг шаардагдана. Хөтөлбөрийн 2 дэх шатны төсвийг 1 дэх шатны хэрэгжилтийг үндэслэн боловсруулна. Санхүүжилтийг Засгийн газар, болон бусад олон улсын байгууллага ба хувийн хэвшлийн байгууллагаас хайх боломжтой.

Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөр

I шат: 2014-2016 он- Улаанбаатар хотын 3 амаржих газар, ЭХЭМҮТ хэрэгжүүлэх (2014-2016)

Тоног төхөөрөмж	Тоо	Нийт зардал (Төг)	Тайлбар
1. Түнхний үений дисплазийн хэт авиан скрининг			
Дижитал ЭХО	15,000,000төг/аппарат*4 эмнэлэг	60,000,000	ЭХЭМҮТ, 1, 2, 3-р амаржих газар тус бүр тус бүр 1
Нярайн үзлэгийн ор	1,000,000төг/ор*4 эмнэлэг	4,000,000	ЭХЭМҮТ, 1, 2, 3-р амаржих газар тус бүр тус бүр 1
Дөрөөвч	50,000төг/дөрөөвч*50ш *4эмнэлэг	10,000,000	ЭХЭМҮТ, 1, 2, 3-р амаржих газар тус бүр тус бүр 1
2. Бодисын солилцооны төрөлхийн эмгэгийн скрининг			
Тандем масс спектрометрийн аппарат	1	850,000,000	ЭХЭМҮТ



Урвалж бодис (бодисын солилцоо)	1 жилд (5000 хүүхэд)	250,000,000	ЭХЭМҮТ
Шинжилгээнд сорьц авах материал а. Цусны шүүлтүүр цаас б. Өсгий цолоогч ланцет	1 жилд (5000 хүүхэд)	2,500,000	ЭХЭМҮТ
3. Сонсголын скрининг оношилгоо			
Сонсголын аппарат (MB11 BERAphone Screener, Maico, Germany, зөөврийн, олон улсад хэрэглэгддэг)	4 эмнэлэг * эмнэлэг тус бүр 2 ш * 21,000,000төг/аппарат	168,000,000	ЭХЭМҮТ, 1,2,3-р амаржих газар
4. Дутуу нярайн ретинопатийн скрининг оношилгоо			
1. Зөөврийн РЭТКАМ 2. Зөөврийн урвуу офтальмоскопи 3. 810 нм долгионы урттай лазер)	1 багц	200,000,000	ЭХЭМҮТ
1. Сургалт (гадаад)	1 удаа	96,000,000	4 эмч, мэргэжилтэн * 4 эмнэлэг
2. Сургалт (ажлын байран дээрх)	тасралтгүй	10,000,000	80 эмч, мэргэжилтэн * 4 эмнэлэг
3. Судалгаа, бүртгэл	1 удаа жилд*3 жил	20,000,000	
4. Сурталчилгаа, ухуулга, нөлөөлөл	Тасралтгүй	150,000,000	
Нийт		1,820,500,000	